**НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2014 оны 10 сарын 26 өдөр Дугаар А/63 Улаанбаатар хот

Томилолтын зардал гаргуулах тухай

Монгол Улсын "Биеийн тамир, спортын тухай" хуулийн 10 дугаар зүйл, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтыг хэрэгжүүлэх, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/333 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Иргэдийн спортын III наадмын Гэр бүлийн буухиа тэмцээнийг 2014 оны 10 дугаар сарын 25-нд Багануур дүүрэгт, Шагайн наадгайн тэмцээнийг 2014 оны 10 дугаар сарын 26-нд Багахангай дүүрэгт тус тус зохион байгуулсугай.

2. Мэргэжилтэн Б.Түвшинбаяр, Б.Батсайхан, Г.Бямбасайхан нарын 2014 оны 10 дугаар сарын 24-нөөс 27-ныг хүртэл ажиллах томилолтын зардлыг олгосугай.

3. Томилолтын зардлыг хавсралтаар баталсугай.

4. Томилолтын зардал 210.000 /хоёр зуун арван мянга/ төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын орон нутгийн төсвийн иргэдийн спортын наадмын зардлаас гаргахыг нягтлан бодох О.Эрдэнэцэцэгт зөвшөөрсүгэй.

5. Тэмцээнүүдийн урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, тэмцээнийг өндөр хэмжээнд зохион байгуулан тайлагнахыг мэргэжилтэн Б.Түвшинбаярт даалгасугай.

ДАРГА Ж.ГАНБОЛД

1150500145